



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

ТУЗ-ын гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 96.5, Техник импорт ХК-ийн “Дүрэм”-ийн 7.47.11 дэх хэсэг, Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хурлын 05 тоот тогтоол, Техник импорт ХК-ийн 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн

Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. 2024 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



Д. ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ
ХУВЬЦААТ КОМПАНИ

ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Ногдол ашгийн талаарх ТУЗ-ын
шийдвэрийг батлах тухай

МУ-ын Компанийн тухай хуулийн 46.1, 46.5, 46.6 дахь хэсэг, Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 05 тоот тогтоол, Техник импорт ХК-ийн 2025 оны 04-р сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. 2024 оны ногдол ашгийн талаарх ТУЗ-ын шийдвэрийг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Компанийн жилийн үйл ажилллагааны
тайлан батлах тухай

МУ-ын Компанийн тухай хуулийн 96.4, Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 05 тоот тогтоол, Техник импорт ХК-ийн 2025 оны 04-р сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. 2024 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайланг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Компанийн жилийн үйл ажиллагааны
төлөвлөгөө батлах тухай

Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 05 тоот тогтоол, 2025 оны 04 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. 2025 оны компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Хавсралтын дагуу баталсугай.
2. Төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /Т.Тунгалаг/-д үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Ногдол ашгийн тайлан батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46.15 дахь хэсэг, Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02-р сарын 14-ний өдрийн 01 тоот тогтоол, 2025 оны 03-р сарын 18-ны өдрийн 05 тоот тогтоол, Техник импорт ХК-ийн 2025 оны 04-р сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Техник импорт ХК-ийн 2023 оны ногдол ашгийн тайланг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

ТУЗ-ын үйл ажиллагааны тайлан батлах тухай

Техник импорт ХК-ийн “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 12.2 дахь хэсэг, Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03-р сарын 18-ны өдрийн 05 тоот тогтоол, Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Техник импорт ХК-ийн 2024 оны ТУЗ-ын үйл ажиллагааны тайланг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

2025 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн
төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.13 дахь заалт, Техник импорт ХК-ийн “Дүрэм”-ийн 7.11.13 дахь заалт, Техник импорт ХК-ийн “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 12.4 дэхь хэсэг, Техник импорт ХК-ийн 2025 оны 04-р сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Техник импорт ХК-ийн 2025 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг Хавсралт1-т заасны дагуу баталсугай.
2. Тогтоолын дагуу ТУЗ-ын төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, төсвийн зардалд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ын дэргэдэх Цалин урамшууллын хороо /Б.Батсайхан/-нд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



**ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2028 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Техник импорт ХК-ийн “Дүрэм”-ийн 7.11.7 дахь заалт, Техник импорт ХК-ийн ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны 2025 оны 01-р сарын 15-ны өдрийн дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 05 тоот тогтоол, 2025 оны 04-р сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Дараахь нэр бүхий хүмүүсийг 2025 оны Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдээр сонгосугай.

ТУЗ-ын ердийн гишүүд:

1. Т.Тунгалаг
2. Д.Баяраа
3. С.Бүжинлхам
4. Г.Уран-Өлзий
5. Л.Уртнасан
6. Э.Батболд

ТУЗ-ын хараат бус гишүүд:

1. Ж.Баярсайхан
2. Б.Батсайхан
3. Б.Нарантуяа

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг 1 жилийн хугацаатай сонгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдэлж, компанийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл Т.Тунгалаг/-д үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



**ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

ТУЗ-ын дэргэдэх хороодыг
байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэг, Техник импорт ХК-ийн “Дүрэм”-ийн 7.62 дахь хэсэг, “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.5, 8 дугаар зүйл, 2025 оны 04-р сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин, урамшууллын хороог тус тус байгуулсугай.
2. Хороо тус бүрийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

А. Аудитын хорооны дарга	Ж.Баярсайхан
Гишүүд	Д. Баяраа
	Б. Батсайхан
Б. Нэр дэвшүүлэх хорооны дарга	Б. Нарантуяа
Гишүүд	Б.Батсайхан
	Г.Уран-Өлзий
В. Цалин, урамшууллын хорооны дарга	Б.Батсайхан
Гишүүд	Ж.Баярсайхан
	Т.Тунгалаг

3. Техник импорт ХК-ийн Дүрэм, “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д заасан эрх, үүргийн хүрээнд холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ